

БАТЛАВ: БОАЖЯ ХБОБНУГ-ЫН ДАРГА

А.ЭНХБАТ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

НИК ХХК-Н ДОРНОГОВЬ НЕФТЬ ХАНГАМЖИЙН

САЛБАРЫН ДАРГА

Н.НАСАНБАТ

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ НИК ХХК-НИЙ
ХАРЪЯА “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН ТӨСЛИЙН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

РД: 2075261

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Боловсруулсан:

“НИК” ХХК-Н харьяа Дорноговь

НХС-Н ХАБЭА-Н инженер

А.ЭНХСАЙХАН

Байгууллагын танилцуулга

- Дорноговь аймгийн төвд 1938 оны 04-р сард шатахуун хадгалах 4 тн багтаамжийн 1 сав, 5 литрээр тасалж өгдөг гар ажиллагаатай түгээгүүр 1-ийг тавьж, тухайн үеийн аймгийн төвийн албан байгууллагын Эмбиков, Американ-4 зэрэг маркийн автоашиинуудад шатахуун олгодог, аймгийн “Бензин колонк” нэртэй 5 орон тоотой “модон гэр” ажлын байртай байгууллага байгуулагдсан байна. БНМАУ-д /хуучин нэрээр/ авто өртөө байгуулахтай холбогдуулан аймгийн бензин колонкод 1948 онд өргөтгөл хийж, шатахуун хадгалах 60 тн багтаамжийн 2 сав, урсгал түгээгүүр тавьж, өөр газар шилжүүлэн байрлуулж, удирдлага зохион байгуулалт үйлчилгээг нь боловсронгуй болгон бие даасан тайлан тэнцэлтэй болгож, ажиллах хүчийг нэмэгдүүлжээ.
- 1960 оны 1-р сард Авто импорт нэгдлийн харъяа Дорноговь аймаг дахь Нефть бааз болж, 15 орон тоотой 184,8 мянган төгрөгний үндсэн хөрөнгөтэй болсон.
- Улаанбаатар, Замын-Үүдийн төмөр зам ашиглалтанд орсноор манай салбар нефтийн бүтээгдэхүүнийг төмөр замаар шууд татан авдаг болсон.
- БНМАУ-ын Тээврийн яамны сайдын 1978 оны 225-р тушаалаар Дорноговь аймгийн Нефть баазыг дахин өргөтгөж, Тээврийг удирдах газрын харъяаллаас тусгаарлан, шинэчлэн байгуулж, 1978 оны 10-р сарын 24-ний өдрөөс ажиллуулсан байна
- Дорноговь аймаг дахь Нефть хангамжийн салбар 1980, 1987 онуудад барилга байгууламжийн өргөтгөл, сав тоног төхөөрөмжийн шинэчлэл, шатахуун хадгалах савны хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг нефть хангамжийн олон талт арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн байна. Тус аймаг дахь НХСалбар нь зах зээлийн үеийн нийгмийн онцлогод нийцүүлэн олон улсын нягтлан бодох бүртгэлд аймагтаа хамгийн түрүүнд 1996 оны 7-р сарын 1-нээс эхлэн өөрийн санхүү бүртгэлийн ажлыг бүрэн компьютержуулан сүлжээнд оруулан 2013 онд навишин программ оруулж ажилласнаар бүртгэл тооцоонд зарчмын шинэ өөрчлөлтийг зохион байгуулан ажиллаж байна.
- 2011 онд ПЕТРОВИС ХХК, НИК ХХК –ний хэмжээнд анхны 5000м³-ын багтаамжтай ШТМ-ыг хадгалах босоо савыг барьж ашиглалтанд оруулсан. Мөн энэ онд агуулахын зам талбай болон ачих байгууламжуудыг бүрэн шинэчлэн өргөтгөлийн ажлууд хийгдсэн.
- НИК ХХК-ий харъяа Дорноговь НХС-нь нийт 88 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа Дорноговь аймгийн хэмжээнд Замын-Үүд, Эрдэнэ, Дэлгэрэх, Мандах, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Айраг, Сайншанд суманд байрлах 9 суманд байрлах нийт 1 агуулах 14 ШТС-аар дамжуулан гадна дотны хэрэглэгчдэд шатахуун, тос тосолгооны материалыг хугацаанд нь чанартай хүргэж үйлжилж байна..
- Манай салбар нь өөрийн сумдын ШТСтанц, Өмнөговь аймгийн Говь Ойл ХХК, Таван толгой ШТСтанц, Өмнөговь Цагаан хад ХХК, Говь Ойл Цагаан хад ХХК,

Өмнөговь аймгийн Манлай, Баян-Овоо, Ханбогд, Цогт-Цэций, Номгон сумдууд болон томоохон уул уурхай, газар тариалан, авто тээвэр, зам барилгын томоохон хэрэглэгчдэд шатахуун тос тосолгооны материалаар хангалт хийдэг.

- 2013 оны 1-р улиралд вагонцистерн буулгах талбайг өргөтгөж шинээр Евро дизель түлш хүлээн авах зориулалтаар 6 вагонцистерн зэрэг буулгах коллекторыг 1000м³-ын босоо резервуартай холбох технологийн ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулаад байна. Мөн вагонцистернийг 3-аар буулгах коллектороор авдаг байсныг 6 болгон өргөтгөж ашиглалтанд оруулж шинээр автоцистерн ачих

байгуулалтыг шинэчлэн паркын зам талбай болон 5000м³, 1000м³-ын паркын дотор тал, хамгаалалтын далангийн аюулгүй ажиллагааг ханган бетондож ашиглалтанд тус тус оруулсан.

- Нефтийн бүтээгдэхүүний чанарт шинжилгээ хийх зориулалтын лабораторийн өрөөг шинэчлэн тохьжуулан ажиллаж байна. Мөн НХС-ын харъяа аймгийн төвийн болон суман дахь ШТС-уудын технологийн дагуу сав тоног төхөөрөмж суурьлуулж зам талбайг бетондож, стандартын дагуу хөрөнгө оруулалт хийгдэж өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулж байна



Төслийн товч тодорхойлолт, танилцуулга

Төслийн ерөнхий мэдээлэл

Нэр: Газрын тосны бүтээгдэхүүний агуулах

Зорилго: ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүн шууд импортлож Сайншанд сумын төв дэх өөрийн харъяа газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станцуудаар

дамжуулан хэрэглэгчдэд жижиглэн борлуулалт хийх замаар өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "НИК" ХХК, Улсын бүртгэлийн дугаар 9, Регистрийн дугаар 2075261. "Петровис Ойл" ХХК-ийн Ерөнхий захирал О.Содбилэг, "НИК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Наранбат.

Хэрэгжүүлэгч хаяг: 210646, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-51 А.Амарын гудамж 8. Утас:330505 Факс:327288

Байршил Дорноговь аймгийн Сайншанд сумын 8р баг нутаг дэвсгэрт 78869,0 м2 талбай эзэмшин оршино.

Танилцуулга: "НИК"-ийн харъяа Дорноговь аймаг дахь НХСалбар нь Агуулах, Борлуулалт, ИТА, санхүү, захиргаа гэсэн 5 алба нэгжтэй, нийт 33 албан хаагчид ажиллаж байна.

Төсөл хэрэгжих орчны тойм зураг



/Зураг-1 Агуулахын ачих АСН-5 бетонон талбай/



/Зураг-2 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах дээр босоо цилиндр ган савнууд суурилуулсан байдал сав паркын далан/

Төслийн хүчин чадал /голлох үзүүлэлтээр/, техник технологи:

Тус агуулахын газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савны нийт багтаамж 10,000м3. Үүнээс 400м3-ийн 10 ширхэг, 1000м3-ийн 1 ширхэг, 5000м3-ийн 1 ширхэг , ширхэг савтай. Сав тус бүр ачих буулгах технологийн шугам хоолой, ослын хаалт, насосны станц бусад хэрэгслэлээр стандартын дагуу тоноглогдсон.

Үндсэн тоног төхөөрөмж: Агуулахын одоо ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмжийг хүснэгтээр харуулав. /Хүснэгт-1/

| Д/д | Тоног төхөөрөмж | Марк | Тоо хэмжээ, ш чадал |
|-----|--|-------------------------------|---------------------------------|
| 1 | 400м3-ийн эзэлхүүнтэй босоо цилиндр ган сав | PBC-200 | 10 |
| 2 | 1000м3-ийн эзэлхүүнтэй босоо цилиндр ган сав | PBC-300 | 1 |
| 3 | 5000м3-ийн эзэлхүүнтэй босоо цилиндр ган сав | PBC-400 | 1 |
| 4 | Буулгах төхөөрөмж | ACH-5 | |
| 5 | Вагон эстакад | | 12 байраар нэгэн зэрэг буулгана |
| 6 | Автоэстакад | AUTOWER | 4 автоцистерн зэрэг ачина |
| 7 | Насосны станц | 6НКЭ-9/1 АСВН-80 DICKOV | 90-120 м3/цаг 30м3/цаг |
| 8 | Төмөр замын салаа зам | | 2ш 1350м урт |
| 9 | Нефтеловушка | 5x12 | 1 |
| 10 | Ослын сав | 50м3 | 1 |
| 11 | Хөргөлтийн систем | | 1 ком |
| 12 | Хөөсний камер | | 26 |
| 13 | Усан сан | 400м3 | 1 |

Төслийн технологи /дэвшилттэй болон дутагдалтай тал/

"НИК" ХХК-ийн ГТБ-ний агуулах нь 78869,0м2 талбай эзэмшдэг бөгөөд технологийн дараах үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Вагонцистернээс шатахуун хүлээн авах
- Шатахууныг ил байрлалтай босоо цилиндр ган савнуудад нөөцлөн хадгалах
- Шатахууныг автоцистернд бөөнөөр ачих

ГТБ-ний агуулахад вагонцистернээр тээвэрлэгдэн ирсэн шатахууныг өөрийн салаа төмөр замын вагонцистерн буулгах төхөөрөмжөөр дамжуулан битүүмжлэгдсэн шугам хоолойгоор насосны станцын тусламжтайгаар ил нөөцлөх саванд хүлээн авдаг. Уг агуулах нь автобензин, энгийн дизель хөдөлгүүрийн түлш, шатах тослох материал /ШТМ/ хүлээн авч хадгалан өөрийн нэрийн ШТС-аар дамжуулан борлуулдаг.

Галын онц аюултай объект учраас тогтмол галын үзлэг шалгалт дотооддоо хийдэг бөгөөд түүнчлэн мэргэжлийн байгууллагууд болох мэргэжлийн хяналтын газар, онцгой

байдлын ерөнхий газар, байгаль орчны газруудад тус тус жил болгон шалгуулдаг. Батлагдсан хуваарын дагуу бүх савнуудад металл оношлогоо хийж улмаар тухайн савнуудын ханын болон дээврийн гагнуурын оёдлуудад нөхөлт хийсэн, мөн түүнчлэн тэдгээр савнуудын ул сольж хаявч хийсэн. Агуулахын савны паркын даланг бүтнээр нь бетондсон. Савны паркын шугам хоолойнуудыг ил болгосон. Мөн галын хайрган замтай болсон.

500 м3 багтаамжтай усан сантай. Агуулахын хэмжээнд 1 ширхэг гүний худагтай.

Уршилтын алдагдлаас үүсэх агаарын бохирдолтыг бага байлгахын тулд "Газрын тосны бүтээгдэхүүн агуулах" нь шатахуун хадгалах резервуарыг дараах үндсэн тоног төхөөрөмжүүдээр тоноглох шаардлагатай. Үүнд:

- Резервуарын шатахуунгүй хоосон орон зайн дотоод даралтыг тогтоосон хэмжээнд барьж байх зориулалттай амьсгалах клапан
- Резервуарт хадгалагдаж байгаа шатахуунаас дээж авах суурин төхөөрөмж
- Резервуарт хадгалагдаж байгаа шатахууны дүүргэлтийн өндрийг хэмжих зориулалттай төхөөрөмж

Шатахуун хүлээн авах технологи

Газрын тосны бүтээгдэхүүний агуулах дээр шатахуун тээвэрлэн ирсэн вагонцистернийг стандарт /MNS4633-2006/ заасан хугацаанд зогсоон дагалдах бичиг баримтуудыг нь бүрэн шалгасны дараа дээрх стандартын 3.1-3.2 бүлгүүдэд заасны дагуу хэмжилт тооцоололт хийж хүлээн авна. Газрын тосны бүтээгдэхүүнийг вагонцистернээс хүлээн авахдаа тээвэрлэгч байгууллагын өртөөнөөс өөрийн хаягтай тээврийн хэрэгсэл ирсэн тухай мэдэгдэ авмагц газар дээр нь очиж бүтээгдэхүүний нэр, марк , тоо хэмжээ, нийлүүлэлтийн хаяг зэргийг дагалдах баримтуудтай тулгаж гадаад дотоод гэрээ захиалга тохирох эсэхийг хянаж үзээд вагонцистернийг хаяг солих, ямар хугацаа, дараалалтайгаар аль зам дээр тавиулж буулгах талаар захиалга өгнө. Захиалгын дагуу шатахуун буулгах байгууламж дээр вагонцистерн ирмэгц эд хариуцагч нар холбогдох хүмүүсийн хамт тээврийн хэрэгсэл нэг бүрийн дугаар дагалдах баримт лац ломбо галын аюулгүй байдал зэргийг шалгаж буугалтанд хүлээн авсан тухай экспертизийн болон коммерийн актанд цаг хугацааг тодорхой бичиж гарын үсэг зуралцана.

Шатахуун тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн торх нь бүрэн дүүргэлтийн дээд хязгаарт байрласан түвшин заагч /цагаан хил/-тай байх бөгөөд тэр нь нээлхий/ люк/-ий хананд хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байх
- Шатахуун тээвэрлэх тээврийн хэрэгслийн техникийн паспортод заасан тусгай төхөөрөмж болон гал унтраах хэрэгслүүд иж бүрэн, хэвийн ажиллагаатай торх тус бүрд нь зориулалтын шаттай байх
- Торхны амьсгалах хавхлаг, агааржуулагч хоолой, тунадаслах хүйс нь хэвийн ажиллагаатай байх
- Торх тус бүр нь хэмжил зүйн байгууллагын шалгалтанд хамрагдаж баталгаажуулалтын гэрчилгээтэй байх
- Торх нь нэвчилтм шүүрэлтгүй байх
- Давхар болон дан ханатай савны гэмтлийг илрүүлэх боломжоор хангасан байх бөгөөд 5 жил тутамд саванд метал хийцийн ашиглалтын нөөцийн шалгалтыг эрх

бүхий байгууллагаар хийлгэж уг савыг цаашид ашиглах зөвшөөрлийг албан ёсоор авсан байх

- Сав тус бүрийг улсын бүртгэлд хамруулсан байх



/Зураг-3 ГТБ-ний агуулах дээр төмөр замаар тээвэрлэгдэн ирэх газрын тосны бүтээгдэхүүнүүдийг өөрийн вагон эстакадаар дамжуулан хүлээн авдаг ба 12 байраар нэгэн зэрэг буулгана/

Тус агуулах нь сард ойролцоогоор 100 ширхэг вагонцистерн газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авдаг бөгөөд үүнээс:

- А-92 маркийн автобензины- 40 вагонцистерн
- Энгийн дизель Түлшний- 60 вагонцистерн тус тус буудаг байна.

Шатахууныг бөөнөөр хадгалах технологи:

Ууршилтыг багасгах үүднээс ПОНТОН ХӨВӨГЧ бензин савнуудад угсрах шаардлагатай гэж үзсэн учир 2025 онд бензин саванд понтон суурилуулсан.

Шатахуун хадгалах ган савнууд, түүнд тавигдах ерөнхий технологийн үндсэн шаардлага:

Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, нөөцлөх сав нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Техникийн шаардлага хангаж тэгш зөв суурилагдсан, өнгө будаг шинэ, гал хөдөлмөр хамгааллын тэмдэг тэмдэглэгээ хийгдсэн, дугаарлагдсан байх
- Сав нэг бүрийн хэмжилтийн үндсэн өндрийг тогтоож, жил бүр энэхүү хэмжээг хянан баталгаажуулах
- Савны тоноглолууд бүрэн хэвийн ажиллагаатай байх
- Сав нь нэвчилт шүүрэлтгүй, битүүмжлэл сайтай байх
- Техник технологийн шаардлагын дагуу дамжуулах шугам хоолойтой холбогдсон орлого зарлага хийх боломж хангагдсан шугам хоолой холболтууд бүрэн битүүмжлэгдсэн байх

- Бүтээгдэхүүн хадгалах савнаас зарлагын хоолойгоор гарахгүй үлдэх үлдэгдлийн хэмжээг сав нэг бүрээр гарган баталгаажуулсан байх
- Технологийн шугам хоолойн шавхагдахгүй үлдэгдлийн хэмжээг тогтоон баталгуужуулж үлдэгдлийн тооцонд оруулан тооцсон байх
- Техник ашиглалтын паспорт бүрэн хөтлөгдсөн байх
- Сав тус бүрт хэмжилзүйн байгууллагаар хийлгэж батлуулсан онооллын хүснэгттэй байх
- Нөөцлөх сав нь MNS : 5309:2003 стандартын дагуу шаардлага хангасан байх

Бүтээгдэхүүний чанарт тавигдах үндсэн шаардлагууд:

- Батлагдсан шинжилгээний аргын стандартын дагуу гүйцэтгэж стандарт болон чанарын паспортад заасан үзүүлэлтэд тохирч байгаа эсэхэд дүгнэлт гаргах
- Зарлагын саван дахь газрын тосны бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүний агуулахаас хэрэглэгчдэд олгож байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд ачуулсан тухай бүрд чанарын паспорт бичиж баталгаажуулах
- Нэр, марк, зориулалт нь тодорхойгүй болсон газрын тосны бүтээгдэхүүний чанар алдагдах, ус тунадастай болох зэргээр стандартад тохирохгүй дагалдах бичиг баримтгүй тохиолдолд шалтгааныг тодруулан түүний нэр марк зориулалтыг тогтоох стандартын үзүүлэлтийг хангахаар залруулга хийх асуудлыг шийдвэрлэх
- МУ-н хилээр оруулсан ГТБ-ний агуулахад хүлээн авахаас өмнө улсын итгэмжлэгдсэн лабораториор чанарын баталгаажуулалт хийлгэсэн байх шаардлагатай. Бөөнөөр худалдан авсан байгууллагууд болон харъяа ШТС-уудад бүтээгдэхүүний чанарыг дахин баталгаажуулсан байна.
- Хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцохдоо эрх бүхий байгууллагаас гаргасан журмыг үндэслэн баримтлана.

Газрын тосны бүтээгдэхүүний агуулахад дан ханатай РГС маркын хэвтээ, РВС маркын босоо сав давхар ханатай хэвтээ савнууд ашигладаг. Шатахуун нөөцлөн хадгалах резервуар нь дараах шаардлага хангасан байна. /РГС маркийн хэвтээ савны хувьд/

Хадгалах бүтээгдэхүүний хувийн жин 1-ээс илүүгүй

Дотоод даралт 0.07мПа-аас илүүгүй

Вакуум 0.0001 мПа-аас ихгүй

Газраас доош байх гүн 1.2м

Резервуарын геометрийн зөрүү байж болох хэмжээ:

Урт-10мм

Диаметр-20мм

Шулуун шугам -1/150

Резервуарын битүүмжлэлийг 0.025 мПа даралтаар (агаараар) эсвэл ажлын даралтыг 1.25 дахин ихэсгэсэн шингэнээр 3 минутын турш шахаж шалгана.



/Зураг-4 Агуулахын газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савны нийт багтаамж нь 10,000м³ ба нийт 12 ширхэг босоо ган савнуудтай байна./

Газрын тосны бүтээгдэхүүний ууршдаг чанар нь хадгалалтын үед ихээхэн хэмжээний алдагдал гарахад хүргэдэг. Ууршилтын явцад хамгийн үнэ цэнэтэй, хөнгөн хэсэг нь үгүй болдог. Ийм шалтгааны улмаас газрын тосны бүтээгдэхүүнүүдийг хадгалах зориулалттай савнуудын хийцэд бат бөх эдэлгээ удаантай байх зэрэг шаардлагуудаас гадна ууршилтын алдагдлыг бага байлгах шаардлага тавигддаг. Гаднах агаарын хэм нэмэгдэхэд саван дахь бүтээгдэхүүн мөн халж улмаар эрчимтэй уурших ба энэ үед үүссэн уурын илүүдэл хэсэг нь агаарт цацагдана. Орчны агаарын даралт буурахад мөн ийм байдал ажиглагдана. Агаарын хэм буурахад эсвэл орчны агаарын даралт өсөхөд савны хоосон орон зай дахь уур конденсацлагдах ба энд тодорхой хэмжээний сийрэгжилт үүснэ.

Ингэснээр гаднаас цэвэр агаар сорогдон орно. Үүнийг бага амьсгалах гэнэ. Харин хадгалах савнаас зарлга гаргах үед саванд сийрэгжилт үүссэний улмаас гаднаас агаар сорогдон орно. Үүнийг их амьсгалах гэнэ.

Савны лавлагааны үндсэн үзүүлэлт:

| Савны тэмдэглэгээ | Нэрлэсэн м3 | Ашигтай м3 | Хананы диаметр м | Хананы өндөр м |
|-------------------|-------------|------------|------------------|----------------|
| PBC-200-СК | 400 | 400 | 6.63 | 5.96 |
| PBC-200-СП | 1000 | 1000 | 6.63 | 5.96 |
| PBC-300-СК | 5000 | 5000 | 7.58 | 7.45 |

ЖИЧ: СК.С, СП.С -+40С-ээс -65С-д ашиглагдах хөвүүргүй ба хөвүүртэй хөдөлгөөнгүй дээвэртэй савнууд.

Босоо ган саванд дараах үндсэн тоноглолууд байх шаардлагатай Үүнд:

1. Гэрлийн люк
2. Агаажуулалтын хоолой
3. Гал хамгаалагч
4. Механик амьсгалах клапан
5. Хэмжилтийн люк
6. Түвшин хэмжигч
7. Цэвэрлэгээний люк
8. Ус юулэх буюу цоргот крант
9. Хаалтуур
10. Орлого зарлагын хоолой
11. Нэвтрүүлэх төхөөрөмж
12. Хаалтуурын удирдлага
13. Шингэний хамгаалах клапан
14. Дээж авагч
15. Хөөсний генератор

Амьсгалах клапан ажиллахгүй болсон үед хамгаалах клапан ажиллах ба тэр нь тооцоот даралт ба сийрэгжилтийг 5-10%-аар ихэссэн үед л ажиллана.

Шатахууныг автоцистернд бөөнөөр ачих тээвэрлэх технологи:

Автоцистернд газрын тосны бүтээгдэхүүн ачих технологи үйл ажиллагаа:

Тухайн өдөрт зарлага гаргах савны дугаарыг хүмүүст мэдэгдэж чанарын шинжилгээ хийлгүүлэн ачилт эхлэхээс өмнө паспортуудыг нь авсан байна. Батлагдсан хуваарийн дагуу эд хариуцагч нар аль савнаас ямар төрлийн бүтээгдэхүүн хэдий хэмжээтэй ачигдахыг урьдчилан төлөвлөсөн байна. ГТБ тээвэрлэхээр ирсэн автоцистернүүдийн галын аюулгүйн шаардлага буюу галын хор түүний цэнэг ажиллагаа газардуулга оч баригч гэх мэт зүйлсийг хангаж байгаа эсэх холбогдох үүрэг бүхий хүмүүс торхны бүрэн бүтэн байдал баталгаажилт цэвэрлэгээ ариун цэвэр бичиг баримтын бүрдэлтийг эд хариуцагч нар тус тус шалгаж ачилтанд орох зөвшөөрөл олгож дараалалд оруулан оч баригч олгоно. Зөрчилтэй автоцистернд ачаа ачихыг хориглож, замын хуудсанд тэмдэглэн буцаана.

Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх үйл ажиллагаа:

- Тээвэрлүүлэгч нь автоцистерн, чиргүүлийг ачаанд оруулахын өмнө үзлэг хийж MNS 3043-96 стандартын дагуу болон компаны тээврийн хэрэгслийн чеклистээр шалгаж шаардлага хангасан нөхцөлд ачаа олгоно
- Ачилтын хувийн жинг MNS 4633-98 стандартын дагуу хэмжилт хийж зарлагын падаанд бичиж бүтээгдэхүүнийг жолоочид хүлээлгэн өгнө.
- Тээвэрлэгч нь дээрх стандартын 2.1.3-т заагдсан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр ачааг тээвэрлэнэ.
- Тээвэрлэлтийн явцад гарсан хохирол зөрчлийг тээвэрлэгч бүрэн хариуцна.



Зураг-5 Агуулахаас автоцистернд ачилт хийж байгаа технологи ажиллагаа харагдаж байна /

"НИК" ХХК-ын Дорноговь аймгийн Сайншанд суман дахь Газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь өөрийн 10 ширхэг автоцистернээр Өмнөговь аймгийн 5 сум болон Сүхбаатар аймгийн 5 сумдуудад, газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэн хүргэдэг байна. Үүнээс:

- Норд бенз маркийн 32425 л багтаамжтай автоцистерн 1 ширхэг
- Шакмень маркийн 30370 л багтаамжтай автоцистерн 1 ширхэг
- Норд бенз маркийн 35000 л багтаамжтай автоцистерн 8 ширхэг

Техник, тоног төхөөрөмж / нэр төрөл, тоо хэмжээ/

Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын тоног төхөөрөмж байгууламжийн техникийн үндсэн үзүүлэлтүүд:

- ✓ **Резервуарын байгууламж:** Уг байгууламж нь 400м³-ийн 10ш, 1000 м³-ийн 1ш, 5000 м³-ийн 1ш, 12 ш босоо цилиндр ган савнуудтай сав тус бүр стандартын дагуу амьсгалах клапан шүүр бүхий орлого зарлагын шугам, арматуурууд болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.
- ✓ **Вагон эстакад нь:** Нэгэн зэрэг 12 вагонцистернээс 2 төрлийн шатахуун хүлээн авч буулгах АСН-5 маркийн төхөөрөмжөөр тоногдлогдсон, шатахууны коллектор, технологийн дамжуулах шугам хоолойн хаалт арматур шүүр-тунгаагуур бүхий буулгах худагтай. Төмөр замын салааны урт нь 1170 м, вагон эстакад нь үйлчилгээний зориулалтын тавцан галын аюулгүйн битүүмжлэл хангасан гэрэлтүүлэгтэй асгарсан газрын тосны бүтээгдэхүүн хөрсөнд нэвчихээс сэргийлсэн бетонон хучилттай вагоны зогсоолтой. Хур тунадасны бохир ус цуглуулж зайлуулах байнгын ажиллагаатай шугам хоолой 50 м³-ээс доошгүй багтаамжтай цуглуулах худагтай. Буулгах хэсэг нь статик цахилгаан цэнэгжилтээс хамгаалагдсан газардуулгын хүрээнд холбогдсон ба буулгах тоноглол бүр уян газардуулгатай.
- ✓ **Автоэстакад:** нь нэгэн зэрэг 4 автоцистернд 2төрлийн шатахуун бөөнөөр ачих БНХАУ-н автовер маркын бүрэн автомат ачигчаар тоноглогдсон. Уг төхөөрөмж **байгаль орчинд** ээлтэй гадагш алдагдах ууршилтыг хийг сорох тоноглолтой цагт 70м³ шахах насос суурилуулсан. Ачих талбай бүрэн бетонон хучлагатай.
- ✓ **Насосны станц:** Газрын тосны бүтээгдэхүүнийг сорох, шахах зориулалт бүхий олон улсын стандарт шаардлага хангасан ОХУ-д үйлдвэрлэгдсэн 90-120 м³/цагаас доошгүй хүчин чадалтай вагонцистернээс бүтээгдэхүүн буулгах 6НКЭ-9/1 маркийн 2, DICCKOV Germany маркийн 2 ширхэг насостай.
- ✓ **Аянга зайлуулагч газардуулга:** Аянгын цохилт түүний нөлөөллөөс хамгаалах зориулалттайгаар савны парк насосны станц харуулын байр, операторын байр албан контор гэх мэт барилга байгууламжууд аянга зайлуулагч газардуулгын ерөнхий хүрээнд холбосон.
- ✓ **Галын хэрэгслүүд:** Агуулахад гал түймэр гарсан тохиолдолд галын машин саадгүй нэвтрэх тээврийн хэрэгслүүд талбайгаас саадгүй гарах боломжтой зайн хэмжээг "Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын галын аюулгүйн зайн хэмжээ"-н БНБД-ийг баримтлан 2 гарц байгуулсан. Агуулахын хэмжээд газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савнууд хөргөлтийн хөөсний системээр иж бүрэн тоноглогдсон ба байнгын ажиллагаатай 400 м³-ийн 1 ширхэг 250 м³-ийн 1 ширхэг усан сан хөөсний камертай. Бага хэмжээгээр гарсан галыг тархаахгүй унтраах зориулалттай агуулахын нормт галын анхан шатны багаж хэрэгсэл бүхий байруудтай байна.

Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын техникийн түвшин

Тус “Газрын тосны агуулах” нь монгол улсын БНБД-заагдсанаар шатахуун түгээх станцын зэрэглэлээр 2 ангилалд хамаарах ба тухайн БНБД-ын шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Тус агуулахын галын аюулгүйн зай хэмжээг хангасан байдлыг Хүснэгт 2-т, далд савнаас станцын барилга байгууламж хүртэлх зайн хэмжээн норм:

| Д/д | Барилга байгууламж | Станцын ангилал, барилга байгууламжууд хүртэлх хамгийн бага зай, м | | | | | |
|-----|--|--|--------------|---------------|-----|-----|-----|
| | | 1 | 2 | Хангасан эсэх | 3а | 4б | 5в |
| 1 | Зэргэлдээ байгууллагын барилга байгууламжаас | 100 | 40/100/ | 20 | 40 | 40 | 30 |
| 2 | Байгалийн ой Шилмүүст болон холимог навчит | 100 20 | 50 20 | - | 50 | 50 | 50 |
| 3 | Модон материал, хүлэр утаслаг бодис /хөвөн, ноос/ өвс, сүрлийн болон хүлэр задгай асгарсан газар | 100 | 100 | - | 50 | 50 | 50 |
| 4 | Ерөнхий сүлжээний төмөр зам /далангийн зах сэтэрсэн газрын ирмэг хүртэл/ станцад –зөрлөг тавцанд – салаанд | 150 80 60 | 100 70 50 | - | 80 | 60 | 50 |
| 5 | Ерөнхий сүлжээний автозам /зорчих хэсгийн зах хүртэл/- 1,2,3 ангиллын -4, 5 ангиллын | 75 40 | 50 30 | 20 | 45 | 45 | 40 |
| 6 | Орон сууц олон ниитийн байгууллага | 200 | 100/200/ | - | 100 | 100 | 100 |
| 7 | Нийтийн үйлчилгээний ШТС-ын түгээгүүр | 50 | 30 | 5 | 30 | 30 | 30 |
| 8 | Автомашини граж задгай зогсоол | 100 | 40/100/ | 50 | 40 | 40 | 40 |
| 9 | Агуулахад үл хамаарах бохир усны цэвэрлэгээний байгууламж болон насосны станц | 100 | 100 | - | 40 | 40 | 40 |

| | | | | | | | |
|----|--|-----|-----|---|-----|-----|-----|
| 10 | Агуулахад үл хамараах ус дамжуулах байгууламжууд | 200 | 150 | - | 100 | 75 | 75 |
| 11 | Станцын ослын сарай/ аваарийн самбар/ | 60 | 40 | 5 | 40 | 40 | 40 |
| 12 | Галын болон тэсрэлтийн аюултай үйл ажиллагаа бүхий технологийн төхөөрөмжүүд хий шатах төхөөрөмжүүд | 100 | 100 | - | 100 | 100 | 100 |

Төлөвлөгөө хэрэгжих орчны газар ашиглалт , дэд бүтцийн хөгжлийн байдал

-Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр: Аймгийн цахилгаан дамжуулах дэд станцаас 380Вт-ын эрчим хүчний эх үүсвэртэй. Сард 11000.кВт хэрэглэнэ.

-Зам талбай: Цэнэглэх талбай хатуу хучмарлаар хучигдсан.

-Холбоо харилцаа бүх төрлийн телефон утасны сүлжээнд холбогдоно. Бүхий л оператортай холбогдоно.

-Халаалт:цахилгаан зуухтай.

Байгаль орчны шинжилгээ, үндсэн арга зүй

Агаарын бохирдол

1.1 Хяналт-шинжилгээ явуулах шаардлага

Бензин шатахууны ууршилтаас агуулахын орчимд нүүрстөрөгчийн хий тархаж орчинг бохирдуулна.

1.2 Хяналт шинжилгээ хийх үзүүлтүүд

- Газрын тосны бүтээгдэхүүн
- 4 этил хар тугалга
- Үнэрт нүүрс устөрөгч
- Фенол
- Арен
- Нүүрс устөрөгчийн хэмжээ
- Нүүрс хүчлийн дутуу исэл /CO/
- Хүхэрлэг хий /SO2/
- Тоос

1.3 Дээж авах цэг

-Шатахуун түгээх станцын орчмоос

- Шатахуун цэнэглэх түгээгүүрийн орчимд 3 м радиуст

1.4 Хяналт шинжилгээ явуулах хугацаа

- Жил бүрийн хамгийн хүйтэн болон хамгийн халуун улиралд нэгээс доошгүй удаа

1.5 Хяналт явуулах аргачлал

- Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам , УСТ-17.316-80
- Агаар мандлын сорьц авахад тавих ерөнхий шаардлага , УСТ-3384-82
- Шинжилгээний бусад сонгомол арга

1.6 Хяналт-шинжилгээ явуулах тоног төхөөрөмж

- Байгаль орчны шинжилгээний төв лаборатори болон бусад лабораториудын баазад түшиглэн явуулна.

1.7 Үр дүнг бүртгэх , тайлагнах

- Хяналт-шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж үр дүнг гаргуулна. Бохирдлын илрэх тохиолдолд мэргэжлийн болон хяналтын байгууллагуудад шуурхай мэдэгдэж холбогдох арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

Хяналт шинжилгээний үр дүнгийн талаарх мэдээ , тайланг жил бүр байгаль орчны хяналтын байгууллагуудад хүргүүлж байна.

1.8 Агаарын бохирдлын талаар

Тоосжилтыг бууруулах

Төслийн үйл ажиллагаанд ашиглах үндсэн тоног төхөөрөмжүүд болон машин техникийн хөдөлгөнөөс тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулж болзошгүй байдал судалгаанаас харагдаж байна. Иймд эх үүсвэр тус бүр дээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

- Дулааны улиралд хуурайшилтай үед замыг услах зэргээр тоосжилтыг багасгах
- Олон салаа зам гаргахгүй байх

1.9 Хорт хий бууруулах

Судалгаанаас үзэхэд газрын тосны бүтээгдэхүүн станц дээр хүлээн авах хадгалах бөөнөөр ачих үед агаар орчныг бохирдуулах байнгын эх үүсвэр болж байна. Иймээс эдгээр байнгын эх үүсвэрийн хэмжээг бууруулах үүднээс:

- Савны амьсгалах болон хамгаалах клапанг тооцоот даралтанд тохируулагдсан эсэхэд байнга хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж гүйцэтгэх шаардлагатай.
- Ажилтаны буруутай үйл ажиллагааны улмаас саванд бүтээгдэхүүн хүлээн авахдаа халиах, шатахуун түгээх явцад тээврийн хэрэгслийг бакыг дүүргэх зэргээр шатахуун ихээр алдагдах боломжийг үүсгэхгүй байж анхаарал болгоомжтой хэмжилт тооцоололтыг нарийн чанд хийж ажиллах шаардлагатай.

2. Усны бохирдол, хомсдол

2.1 Хяналт-шинжилгээ явуулах шаардлага

Станцын байрлаж байгаа орчинд гадаргын ус байхгүй бөгөөд газрын гүний уст цэгийг бохирдуулахгүй байх боломжтой юм. Харин талбайгаас задгай урсах хурын ус нь газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй.

2.2 Хяналт хийх үзүүлэлт

- Газрын тосны бүтээгдэхүүн
- Хар тугалга

2.3 Дээж авах цэг

- Станцын түгээгүүрийн шүүрэлт гоожилтоос бохирдсон байж болзошгүй хурын ус

2.4 Хяналт-шинжилгээ явуулах хугацаа

- Талбайгаас урсах усыг борооны улиралд нэгээс доошгүй удаа
- Шатахуун ихээр алдагдсан тохиолдолд бүрд

2.5 Хяналт-шинжилгээ явуулах аргачлал

- Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн аргачлалаар хийнэ

2.6 Үр дүнг тайлагнах

- Хяналт-шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж үр дүнг гаргуулна. Бохирдлын илрэх тохиолдолд мэргэжлийн болон хяналтын байгууллагуудад шуурхай мэдэгдэж холбогдох арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

2.7 Усны бохирдлын талаар

Төсөл хэрэгжүүлэх талбайд гадаргын ус ил байхгүй боловч хур тунадас ба үерийн усаар газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон хурын ус зөөгдөж тархан газрын гадаргыг бохирдуулахаас хамгаалж далан байгуулах, суваг, шуудуу татах.

3.Хөрсний бохирдол

1.1 Хяналт-шинжилгээ явуулах шаардлага

Станцын байрлаж байгаа орчинд асгаралтаас болж хөрсний бохирдол үүсэж болзошгүй

3.2 Хяналт хийх үзүүлэлт

- Газрын тосны бүтээгдэхүүн
- Хар тугалга

3.3 Дээж авах цэг

- Станцын түгээгүүрийн ойр орчмын 3м

3.4 Хяналт-шинжилгээ явуулах хугацаа

- Шатахуун ихээр алдагдсан тохиолдолд жилд нэг удаа

3.5 Хяналт-шинжилгээ явуулах аргачлал

- Байгаль орчны шинжилгээний төв лабораторид хөрсөн дэхх хүнд элемент /pb/, газрын тосны бүтээгдэхүүн, фенол, үнэрт нүүрсустөрөгч, арений агууламжийг тодорхойлно.

3.6 Үр дүнг тайлагнах

- Хяналт-шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж үр дүнг гаргуулна. Бохирдлын илрэх тохиолдолд мэргэжлийн болон хяналтын байгууллагуудад шуурхай мэдэгдэж холбогдох арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

3.7 Хөрсний бохирдлын талаар

Төслийн үйл ажиллагааны үе шат бүрээс, өөрөөр хэлбэл шатахуун түгээх технологийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй байдал судалгаанаас харагдаж байна.

Иймд эх үүсвэр тус бүр дээр нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

- Байнга машин техник зорчих магадлалтай замуудын замыг шаардлагатай бол засварлах хучилттай болгох , тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх
- Олон салаа зам гаргахгүй байх
- Хур тунадасны бохир ус зайлуулах суваг шуудууг байнгын ажиллагаатай байлгах

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь орчмын байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах зорилготой баримт бичиг юм.

1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|----|---|--|-------------------------------|-------------|-------------------------|------------|---|------------------------------|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | Дамжуулах шугам хоолойнууд, тэдгээрийн холболтын эд ангиуд болон нээх хаах арматуруудын битүүмжлэлүүдээс хөрсөнд шатахуун нэвчих | Дамжуулах шугам хоолойнууд, тэдгээрийн холболтын эд ангиуд болон нээх хаах арматуруудын битүүмжлэлүүдийг байнга шалгаж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх | Сав парк технологийн шугам | | | | Ажил үүргийн хуваарийн дагуу | 7 хоног бүр | |
| | ГХАХ-ийн 34.1.2-ийн дагуу холбогдох мэргэжлийн албадтай хамтран, MNS OHSAS 18001; ISO45001 стандартуудыг хэрэгжүүлж ажиллах | | Ачих буулгах эстакад | | | | Ажил үүргийн хуваарийн дагуу | Тогтмол | |
| | Металл хийцийн оношлогоог ШТС-ын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага MNS-4628-98-ын дагуу 5 жил тутамд хийлгэж байх | | Босоо ган савнууд | | | | | 5н Жилд 1 удаа | |
| 4 | Шатахуун буулгах болон түгээх талбай эвдэрсэн | Шатахуун ачилт буулгалтын үед бетонон талбайд цууралт үүссэнээр завсар зайгаар нь шатахуун нэвчих аюултай учир тухай бүрт засварлах | Ачих эстакад, буулгах эстакад | | | | Үйл ажиллагааны зардлаас | Тухай бүрт | |
| 5 | Гал түймэр гарсан тохиолдолд ажиллах тодорхой бүрэлдэхүүнийг томилгоожуулан дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтын ажиллагааг тогтмолжуулж гал унтраах болон аврах ажиллагааны дадлага, сургууль зохион явуулах | | Агуулах | | | | Ажил үүргийн дагуу хяналт тавих | Тухай бүрт | Гамшгаас хамгаалах тухай хууль 34.1.2; 34.2.4 |
| 6. | Шатахууны агуулахын нутаг дэвсгэрт байх тээврийн хэрэгсэл, үйлчлүүлэгчдэд зориулсан анхааруулах, хориглох тэмдгүүдийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж сэргээн засварлаж байх | | Ачих буулгах талбай | | | | Ажил үүргийн дагуу хяналт тавих | Тогтмол | |
| 7. | Үйлдвэрлэлийн осол болсон болон осолд дөхсөн тохиолдол бүрийг нарийн бүртгэж арилгуулах арга хэмжээг тухай бүрт авч баримтжуулж байх | | Агуулах | | | | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | Жилдээ | Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль |
| | Резервуарын битүүмжлэлийг хэвийн байлгах арга | | Агуулах | | | 2026 | 620,000 | | |

| | | | | | | | |
|-------------|---|---------|--|--|------------------|------|--|
| 8 | Амьсгалын клапанд болон савны битүүмжлэлд улирал бүр хянат тавьж тохируулга хийх | Агуулах | Ажил үүргийн хуваарийн дагуу | | | 2026 | |
| 9 | Цахилгааны шугам сүлжээний ашиглалтын үеийн гал түймрийн аюулгүй байдалд тогтмол хяналт тавих. | Агуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | | | 2026 | |
| 10 | Хуурай хог хаягдлын багтаамж сайтай савыг байршуулах, хогийг сар бүр зайлуулж байх | Агуулах | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд заасан зардал | | | 2026 | |
| 11 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцастай болгох | Агуулах | Дотоод зардал | | | | |
| 12 | Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Агуулах | Дотоод зардал | | | | |
| 13 | ГТБ агуулах технологи, аюулгүй ажиллагааны талаар үлгэрчилсэн заавар гаргаж мөрдүүлж байх | Агуулах | Ажил үүргийн хуваарийн дагуу | | | 2026 | |
| 14 | Орчин нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох явдлыг хянах зорилгоор сав, түгээгүүр буулгалт, саралтын хоолойнуудын аюулгүй байдлыг байнга хянаж, орлого зарлага балансыг зөвлөмжид заасны дагуу нарийн хөтлөх | Агуулах | Ажил үүргийн хуваарийн дагуу | | | 2026 | |
| 15 | Тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийн хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх баталгаажуулах | Агуулах | | | 300,000 | 2026 | |
| 16 | Гал унтраах усны эх үүсвэрийг шийдэх | Агуулах | | | | 2026 | |
| 17 | Гал унтраахад ашиглах хөөс үүсгэгчийн байнгын нөөцтэй болох | Агуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | | | 2026 | |
| 18 | Гал түймрийн багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрэн байлгах | Агуулах | | | 600,000 | 2026 | |
| 19 | /Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм /-БНБД 21.03.04/ хавсралт Б заасан зөвлөмжийн 8.10 заалтын дагуу шаардлагатай /бага ,өндөр өсөлтийн хөөс/ нөөцтэй болох. | | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | | | 2026 | |
| 20 | Мод тарих талаар мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж авч шинээр тарьсан болон өмнөх оны тарьсан модны тоог гаргаж баталгаажуулах | Агуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | | | 2026 | |
| Нийт | | | | | 1,520,000 | | |

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (техникийн, биологийн)

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|----|----------------------------|--|--------------------------------|------------|--------------------------|-----------------|--------------------------------|---------------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Техникийн нөхөн сэргээлт - | Газар шорооны ажил хийхээр бол тухай бүр үнэлгээ хийлгүүлж нөхөн сэргээлт хийх | Агуулах | 1 | Тухай бүрд | - | Тухай бүрд | |
| | | Мод эзэмшлийн талбайд хаягжуулалт хийх | Дорноговь аймаг Сайншанд сум | 1 | Үйл ажиллагааны зардлаас | - | 8сард | |
| | | Мод, бут тарихдаа мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж сургалт авах, үр дүнг тайлагнах | Агуулах | - | - | - | 4,9 сар | |
| 2. | Биологийн нөхөн сэргээлт - | Агуулахын зөвшөөрөгдсөн орчимд мод бут сөөг нөхөж тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Агуулах | 2 | | | 5, 10 сар | |
| | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд идэвхитэй оролцох | Орон нутгаас зааж өгсөн талбай | 2 | 100.000 | 600.000 | 5,10сар | |
| | | Орон нутгаас зааж өгсөн мод тарилтын талбайг тогтуул уснаас хамгаалах овоолго шудуу татах | Агуулах | 2 | | | | 9,10 сар |
| | Нийт | | | | | 600,000 | | |

3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|----|---------------------------------|-----------------------|----------------------------|------------|---------------------|------------------|--------------------------------|---------------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Археологийн дурсгал | - | - | - | - | - | - | - |
| 2. | Палеонтологийн дурсгал | - | - | - | - | - | - | - |
| | Нийт | | | | | | | |
| | | | | | | | | |

4.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Шатахуун түгээх станцын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг эх үүсвэрүүдийг үйлчлэлийн шинж байдлаар нь байнгын үйлчлэлтэй, тогтмол биш үйлчлэлтэй, санамсаргүй үйлчлэлтэй гэж ангилан үзэж болно. Шатахуун түгээх станцад шатахууныг резервуарт юүлэн авах технологийн үйл ажиллагааны үед резервуараас зайлшгүй түрэгдэн гарч агаарт цацагдан бохирдуулж байдаг хаягдал бол шатахууны "их амьсгалалт"-ын алдагдал юм. Тогтмол биш үйлчлэлтэй бохирдуулагчид авто цистернээс шатахуун хүлээн авах үедээ хэмжилт тооцоололтыг алдаатай хийснээс шалтгаалан резервуарыг халиаснаар шатахуун асгах, авто машины шатахууны савнаас шатахууныг халиах, асгах зэрэг байнга байдаггүй үүсвэрүүдийг хамааруулж болно. Санамсаргүй үйлчлэлтэй үүсвэрүүдэд нөөцлүүр сав, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхэд, мөн технологийн шугам хоолой бусад төхөөрөмжүүдийн битүүмжлэл алдагдсан үед болон аваарын үед шатахууны алдагдал гаргаснаас шалтгаалан бий болох бохирдуулагч үүсвэрүүд хамаардаг. Хоёр ба гурав дахь үүсвэрүүд нь агаарын бохирдолт үүсгэхээс гадна мөн хөрс, гадаргуугийн болон газар доорх усны бохирдолтыг ч үүсгэж болно

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|----|----------------------|---|-------------------------------|-------------|------------------------|------------|------------------------|---------------------|--|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Ахуйн | Нийгмийн болон хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын хүрээнд бодитой ажил хийж гүйцэтгэх /Сайншанд сумаас зааж өгсөн 2 гаас багагүй талбайг цэвэрлэх акт үйлдэх | Агуулах | Төг | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | жилд | |
| | | -Хог хаягдлыг ангилан ялгаж хийх боломжтой зориулалтын сав авч ялган таних тэмдэг тавьж байршуулах -Байгаль орчны хамгаалах MNS 45001:2008 стандартын дагуу таних тэмдэг тавиж ялгаж хаях | Агуулах | Төг | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | Жилд | Байгаль орчны хамгаалах MNS 45001:2008 |
| | | Хог хаягдлыг тогтмол тээвэрлэх арга хэмжээ авах -Аймгийн тохижилтын газартай гэрээ байгуулж хогийг ангилах ачуулах | Агуулах | Төг | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | Сар бүр тогтмол | |
| | | ШТС-н тогтмол их цэвэрлэгээ сар бүр хийх | Агуулах ШТС | Төг | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | Сар бүр тогтмол | |
| | | Хог хаягдал хадгалах түр цэг болон бохирын цооногийг улирал бүр | Агуулах ШТС | Төг | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | Жилд | |

| | | | | | | | | | |
|----|------------|---|----------------|-----|---------|---|---------|--------------------|--|
| 2. | Үйлдвэрийн | - | - | - | - | - | - | - | |
| 3. | □ Аюултай | Аюултай Хог хаягдлыг тогтмол тээвэрлэх арга хэмжээ авах -Аймгийн хот тохижилтын газартай гэрээ байгуулж хогийг ангилах ачуулах - | Агуулах ШТС | Төг | 240,000 | 4 | 960,000 | Сар бүр тогтмол | |
| 4. | Нийт | | | | | | 960,000 | | |

5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|----|--|---|--|------------|---------------------|------------------------|--------------------------------|--|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | |
| 1. | Газрын тосны ууршилт | Хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах | Агуулах, борлуулалтын алба | | | /Дотоод зардал/ | 2026 | Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаал |
| 2 | Шатахуун асгаралт | Шугам хоолойн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллах | ИТА, агуулах | | | Дотоод зардал | 2026 | - |
| 3 | Газрын тосны бүтээгдэхүүнийг ачих буулгах, тээвэрлэх үед орчинд алдагдах, тархах | -Алдагдсан газрын тосны бүтээгдэхүүнийг цэвэрлэх саармагжуулах арга хэмжээ авах багаж хэрэгсэлтэй болох -Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, тэмдэг тэмдэглэгээ байршуулах | Нийт ажилчид Захиргаа | | | 500,0 1,000,000 | 2026 | Галын аюулгүй байдлын тухай хууль |
| 4 | Галын аюул, цахилгааны гэмтэл | Бүх төрлийн тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг хэмжиж баталгаажуулах | ИТА, стандарт хэмжил зүйн газартай хамтран | | | Дотоод зардал | 2026 | - |
| 5 | Галын аюул, цахилгааны гэмтэл | Барилга байгууламжийн доторхи цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт монтажийг галын аюултай байгууламжид зориулсан стандартын дагуу хийж, тогтмол үзлэг шалгалт хийж байх | ИТА, ЦТС хамтран | | | Дотоод зардал | 2026 | - |

| | | | | | | | | |
|---|-------------|--|---------|--|--|------------------|------|-----------------------------------|
| 6 | Галын аюул | Галын аюулаас хамгаалах болон ил гал гарахыг хориглосон бүс тогтоож, анхааруулга санамж, зурагт самбар, тэмдэг тэмдэглээг хийж тавих | Агуулах | | | 500,000 | 2026 | Галын аюулгүй байдлын тухай хууль |
| | Нийт | | | | | 2,000,000 | | |

6.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|----|--|--|---|--------------------------------|---------------------|------------------|---------|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Агаар Нийт тоос (TSP), PM _{2.5} , PM ₁₀ Хүхэрлэг хий, азотын давхар исэл, угаарын хий (SO _x , NO _x , CO _x) | Буулгалтын талбай Ачилтын талбай Вагон эстакад | -Тоосжилтыг PM _{2.5} , PM ₁₀ гэсэн 2 үзүүлэлтээр, улирал бүр хэмжих | Улиралд 1удаа /жилд 4 удаа/ | 58,300 | | | MNS 0017-2-5-12:1988, MNS:5365:2004, MNS:5919:2008, MNS:4585:2016 MNS:5885:2008 |
| 2 | Усны ерөнхий үзүүлэлт: (рН, хатуулаг, хлор, төмөр, нитритийн ион, аммонийн ион, кальци, магни, фтор), нян судлал: гэдэсний савханцар, бактерийн ерөнхий тоо, pseudomonas aeruginosa | - | Нян судлал сар бүр, Ерөнхий үзүүлэлтүүд улиралд 1 удаа | Улиралд 1удаа /жилд 4 удаа/ | 58,300 | 700,000 | | -усны дээжний сав, 500 мл -MNS 0900:2005 -MNS 1097:1970 -MNS 6546:2015 -MNS ISO 6222:1998 -MNS ISO 9308-1:1998 |
| 3 | Хөрс агрохими: Анхан шатны боловсруулалт, сульфат-SO ₄ , фосфор-P ₂ O ₅ , нитрат-NO ₃ , ялзмаг, рН-метр, чийг Хүнд металл: Кадмий-Cd, хар тугалга- Pb, мөнгөн ус- Hg, хром- Cr, цайр- Zn, зэс- Cu, кобальт- Co, стронций- Sr / шатахуун асгарсан тохиолдлын цэгүүдээс авах/ | Буулгалтын талбай Ачилтын талбай Вагон эстакад | рН (хүчиллэг, шүлтлэг) Азот (N) Фосфор (P) Кали (K) Органик бодисын хэмжээ Давсжилт Хагас жилд 1 удаа | Улиралд 1удаа /жилд 4 удаа/ | 58,300 | | | -MNS 5850:2008 -MNS 3310:1991 |
| 4 | Агаар, ус, хөрсний дээж авах мониторингийн цэгүүдийг тогтоож дээж авахдаа сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг байлцуулах | Хөрс агаарын шинжилгээ хийлгүүлэх үедээ | | Улиралд 1удаа /жилд 4 удаа/ | | | | 2026 он |

| | | | | | | | |
|-------------|---|---|--|------------------|--|----------------|---------|
| 5 | Нефтийн бүтээгдэхүүн асгарч байсан газрын хөрснөөс дээж авч Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хүнд металл, органик бохирдуулагч, нефтийн үлдэгдлийг тодорхойлуулах | Хөрс агаарын шинжилгээ хийлгүүлэх үедээ | | Шаардлагын дагуу | | - | 2026 он |
| Нийт | | | | | | 700,000 | |

7. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|-------------|---|------------------|-------------------------------------|--------------------------------|-----------------------|---|------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Нутгийн иргэдийн төлөөлөл | хурал | БОМТ хэрэгжилтийн явцын танилцуулга | 2026 он | 200,000 | Удирдах албан тушаалтан | Сайншанд сум |
| Нийт | | | | | | 200,000 | |

8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|-------------|---|-------------------------|---------------------|------|----|---------------------------|---|
| | | | 2026 он | | | | |
| | | | 5сар | 9сар | 12 | | |
| 1. | Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө | 1,520,000 | Сар бүр тогтмол | | | ХАБЭА-н инженер | Хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн хуваарь |
| 2. | Хог хаягдлын төлөвлөгөө | 960,000 | Сар бүр тогтмол | | | ХАБЭА-н инженер | |
| 3. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 700,000 | 3,6,9,12 саруудад | | | ХАБЭА-н инженер | |
| 4. | Орчны тохижилт Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 600,000 | + | + | | ХАБЭА-н инженер | |
| 5. | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2,000,000 | Сар бүр тогтмол | | | ХАБЭА-н инженер | |
| 6. | Удирдлага зохион байгуулалт, тайлагнах төлөвлөгөө | 200,000 | | + | | ХАБЭА-н инженер | |
| Нийт | | 5.980.000 | | | | | |